

ТҮҮХ, СОЁЛ,
БОЛОВСРОЛ,
ШАШИН

**МОНГОЛЫН ХААДЫН
ТҮҮХЭЭС**

Д. Цэдэв

Монголын эрдэмтэн Ишбалжирын (1704 — 1788) «Галбарвасан модун» гэдэг энэ зохиол монголчуудын төвд хэлээр ном зохиолоо хийдэг уламжлалаар төвдийн (чойгад) судар номын хэлээр зохиосон болой.

Бидний өгүүлэн буй Ишбалжирын (1748) «Галбарвасан модун» нэрт энэ ном 4 бүлэгтэй, үүнд: «Энэтхэгийн түүх» (2—95), «Төвдийн түүх» (95—270), «Хятадын түүх» (270—300), «Монголын түүх» (300-317) -ийг агуулан бичсэн ажээ.

Ер нь уг зохиолд Ишбалжир Азийн тэргүүлэх 4 улс хэмээхүй Энэтхэг, Төвд, Хятад, Монголоор үлгэрлэн Азийн олон улс, орон судлалын хүрээнд монголын түүх түүний дотор монголын хаадын язгуурын гарбал, төр ёсны сургаал, төрийн алтан аргамж түүний уламжлал, шашин (дээдийн ном) соёлын харилцааны түүхийг өгүүлэн гаргажээ.

Бидний бодоход анхааран тэмдэглүүштэй нэгэн асуудал Ишбалжирын «Галбарвасан модун» гэдэг зохиолд « Монголын нууц товчоо»-нд хол ойроор холбогдох нижгээд бүхий мэдээ баримт агуулагдаж байгааг анхаарахгүй орхиж болохгүй мэт санагдана.

МНТ-ны судлалд хол ойроор холбогдох төвд хэлээр буй монгол, төвдийн мэргэдийн түүх шаштир нижгээд, нижгээд буй хэдийч бидний энд нэгэнт өгүүлэн буй Ишбалжирын «Галбарвасан модун» нэрт зохиолын орчуулгыг хэвлэн нийтэлж байгаа учраас уг зохиолд хэдүйн холдсон мэт зарим мэдээг аль нэгэн талаас тодруулахын учирт үүнлүгэ нөхцөлдсөн төвдийн түүхч Шоннүбалын (1392—1481) «Хөх дэвтэр» гэдэг зохиолоос МНТ-нд багтах монгол хаадын язгуурын төрөл дамжлагын лавлагаа баримтыг харьцуулан цөөн ганц нэгэн жишээгээр хашиж өгүүлэюү.

Ишбалжирын «Галбарвасан модун»-д монгол хаадын язгуурын төрөл дамжлагыг тодорхойлон Бөртөчиноор өгүүлэх нь: «Бартачино (Бөртөчино) түүний хүү Батай-хан, Батача-ган (хан) 2»¹ «Батача хан»² (хан) «Батачахан»,³ «Батачихан»⁴ «Бат цагаан»⁵ гэжээ. Ингэхэд бидний өгүүлэн буй «Батачаган (хан)» хэмээх нэрийн учир холбогдлыг МНТ-ны судалгааны мэдээгээр шахаж үзэхэд Монголын нууц товчоо»-нд улираан тогтсон «Батцагаан»⁶ гэдэг нэрийн эртний хэлбэр «Батцагаан бус харин «Батача хан» гэж буй нь эртний хэлбэрээ⁷ хадгалж байна гэж хэлэх үндэстэй мэтээ.

Өдгөө бид энд нэгэнт мэдэгдэхүүн болон улиран ирсэн сурвалж бичгийн мэдээгээр тухайлбал «МНТ»-г хятад үсгийн галигт буулгаж тэмдэглэсэн байдлаас жишээлэн ажиглахад Чингис хаан хэмээхүйг «Чингис ха-хан» (хаан) гэсний «хан» бол «Батачи хан»-ы «хан» мөн буюу өөрөөр хэлбэл «Ха хан» нь хаан луга дүйж, «Батачи ган, (хан) » ны хан нь бага хан луга дүйцүүлсэн утга заажээ.

Шоннүбалын (1392—1481) «Хөх дэвтэр»-т дурдсанаар “Тэнгэрийн хүү Бартачи түүний хүү Барчэ ган» гэжээ. Бидний өгүүлэн буй энэхүү

«Барчэ ган» хэмээх нэр монголын хаадын язгуурын төрөл дамжлагат зөвхөн Шоннүбалын «Хөх дэвтэр»-ийн мэдээгээр л орсон ажээ. Харин бидний үзэж байгаагаар бол энэ нэр эртний хэлбэрээр «Барчэ ган» гэдэг нь Боржигон овгийн нэрийн эртний хэлбэр болохыг өгүүлж гэлтэй.

1. Ишбалжирын «Галбарвасан модун» гэдэг зохиолд «хор юл дү...»¹ (Эртийн Монголын оронд...) гэж буй нь «хор» бол Монголчуудын эртний өвөг хүннү улсыг зааж байна. Хятад сурвалж бичигт «хүннү» гэдэг нэрийг «Шүннү» гэж тэмдэглэдэг. Иймд Хүннү гэдэг энэ нэр монголчуудыг «хүн» улс гэж байснаар нэгэнт тогтсон нэр ажээ гэлтэй.

2. «Согюлдү²...» (Монгол оронд) гэж буйгаас «Сог» гэдэг нь үгчлэн орчуулбал «дал» гэсэн утгатай үг. Монголчуудын дотор далаар төлөг тавьдаг зан үйлээс үүсгэлтэй мэт ч өгүүлдэг. Харин Ишбалжирын «Галбарвасан модун»-д өгүүлснээр «Сог юл дү...» гэдэг нь «Их Монголын»³ үеийг агуулан нэрлэжээ гэх үндэстэй мэтээ.

Ишбалжирын «Галбарвасан модун»-д «Чингис 31 насны дээр солонгосын Ча-ган (хан) хаанг эрхэндээ хураах бөгөөд түүний охин Хулангаог хатнаар авсан»⁴ гэжээ. Бидний энд өгүүлэн буй «Солонгос» гэдэг нь одоогийн Солонгос улс биш юм. Учир нь Ишбалжирын «Солонгосын Ча-ган (хан) » хаан гэдэг нь «Солонгосын Бух цагаан хаан»-г хэлж байна. «Хулан хатан» бол уваш мэргэдийн ноёны дайр усны охин болохыг «МНТ»-нд бодитой тэмдэглэжүү. Иймд «Хулан хатан» бол солон баргын солонгосын Хулан хатан юм.

Ишбалжир «Галбарвасан модун»-д⁵ «Гаули»⁵ гэж уг орчуулгын 8 талд бичсэн байгаа нь одоогийн Солонгос улс мөн. Төвд, сурвалжийн мэдээгээр «Гаули» гэдгийг Солонгос буюу Гуулин улс хэмээх болой. Ер нь Ишбалжирын «Галбарвасан модун» гэдэг зохиолыг цаашид лавшруун судлах шаардлагатай чухал бүтээл юм.

Умарт этгээдийн Монголын¹ зүгт хамааруулахад Монголын² (Монгаол) (Ой-род) Ойрад, хятадын Зүрчид, төвдийн шар югэр, хотонгийн хасаг-Бүрүд, Оросын зүгт Хита уулыг хамаарах буй. Түүний дотор ялгуусны шашин дэлгэрснээс түүнд сүслэхүй Монгол, Халх, Ойрадаас уридынх дотоод цахар 8 хошуу (Чагар), Ордос (ордусу) 6 хошуу буюу 7, Түмэд 2, Дүрвэнхүхид нэг, Урад 3, Муумянган (Мөүмэнгуан) 1, Абагау 4, Сүнид (соу-нид) 2. Хүчүд 2, Үзэмчин 12 тэргүүтэн, Жарод 2, Найман ба У-хан нижгээд, нижгээд, Он-нод 2. Цоохор халх нэг, Баарин 2, Хишигтан нэг, Ар хорчин нэг, зүүн Хорчин 10, зүүн Түмэд нэг, Монголжин харчин нэг, Харчин 3 хошуу сэлтэст их хошуу 49, 6 чуулганд харихуй буюу. Халх 4 аймаг 7 хошуу ба Ойрадад Баргуд Бурад, Хойд батуд, хошунон. Торгууд Дүрвэд зунгар буюу 4 хошуу буй бөгөөд заримаас хойжуу 2-лан 4 болсон бөгөөс Өөлд ангид гарсан тэрхүүг гагцхүүд тоолсноос 4 хэмээсэн (ойрад) буюу.

Тэр тус тусын дотор овог, яс адил бус машид олон болой. Тэд нигуудын хаан их, хан гүрэн түүний ноёдын үндэс дамжлага бол Махасамбхади (Энэтхэг) хаанаас (олноо өргөгдсөн) хаадын уг гарал 1 сая 1 бум 2 түм 500 мянга 114 жил үлэмж одсон цагт бурханы гэгээн Шагж Тува гал морин жилд замбуу тив энд заларснаас 12 зохионгуйг зохиосон тэр гал бар жилд нирван дүр үзүүлснээс нэг мянга 97 жил өнгөрөхөд Төвдийн хаан Лхатотори Няти занба гарсан бөгөөд түүний хүүгийн үндсэнд «Тэнгэрийн суудалт 7 хаан» нэрт гарсаны сүүлд завсар, дээр 2-оос хаан Дигүм зан нэрт түшмэл муу оюут хэмээх хохигдож үхэхийн цагт хөвгүүн Шувуун суудалт, Махан суудалт, Загасан суудалт нэрт 3 буй. Вой-бо, Нян, Гон нэрт 3 оронд зугатса-

наас сүүлд 3 хүүгийн Шувуун сандалт буюу Бүди (Гүн жал) нэрт төвдийн хааныг зохиосон ажээ. Отгон хөвгүүнг монгол хэлээр Бортаси гэх буюу тэр Гонбуу нэрт орноос (Цадын орон) эхнэр (хатан) Гао марал нэртийг аван хөтөлснөөс Монгол оронд хүрч ирсэн бөгөөс Байгаол (Байгал) хэмээхүй их усны сав газар Бурхан Гаолдан (халдун) нэрт ууланд хүрчээ. Тэр өөрийн язгуур яс, уг гарал алинаас ирсэн орон, ба ирэхийн шалтгаан тэргүүтэнг тодруулан өгүүлсэнээр Бэди хэмээхүй хүмүүн аймаг хамаг бүхэн бөөд хүндэлснээс арга ихийг зохиосон тул Бөртө чино хэмээн алдаршжээ. Тэр мэтийг Монголын дэвтэр бичигт заримдаа түүний эцгийг Алтан сандалт мөн хэмээхүй тэнгэрийн сандалт 7 хааны адаг, Сривтив хэмээх лүгэ хутгасан ташаа үзэл болой. Бөртөчино түүнд Батай хан Батача ган нэрт 2 хөвгүүн буйн бага хүүгийн үндэс дамжлагад Димижаг, Хоричар мэргэн (Бадма самбха ва) гэдэг. Агаожам буурал, Салигаол загаод, Ихэ нүдэн, Самсузи, Хали харчү, Боржигдай мэргэн Дуралжин баян нигүүд гарсан. Сүүлд түүний хатан Борогчин гао хэмээхүйд хөвгүүн Дову. Сохор нэрт ортойдоо ганц нүдэг буй, Дову мэргэн нэрт ах дүү 2 гарсаны сүүлд дүү нь тэрээр Хори түмэд язгууртны Алангао (И-лүн) үзэсгэлэнт охин нэрт бөлгөө. Алангао нүүр махлаг өргөн, шүд цагаан тэгш, нүд уужим, өчүүхэн хамар өндөр, бие нүнжлэг, үс хийгээд өнгө гуа үзэсгэлэнт, дуу яруу, хөлс идээш багатай, нууцын орон зөөлөн зохист үс тачархан, их заан одохуй төгөлдөр, одохуй зүүн талаар эргэн одохуй нүд, бие үсгүй, сормос шар, үс үгүй бие нарийн цэх шулуун хэмээхүй билгэ чанар бүрдсэнг авснаас хөвгүүн Балгаодай, Багаонадай 2 гарсан. Дову мэргэнг үхсэний сүүлд (хатан) эм түүний биед солонгон гэрэл туссан, зарим нэгэн бэр зүүдэнд сэтгэл сайтын хөвгүүн нэгэн лүгэ учирч хэмээн зүүдлэв. Алин мэт ч тэр алин болохын шалтгаан бие амгаланг амсахыг шүтсэнээс Бугу хатиг, Бугу шилчи ба Боданчир (бодитой шинэ гарсан) нэрт 3 хөвгүүн гарсан үндэс дамжлага сүүлд удаа дараалан Хатагид, Шалчигаод Боржигон хэмээхүй ноёны үндэс 3 гарчүү. Тэрхүү хүмүүний уг дамжлагыг үзэхэд уг гарал ариун бөгөөд сайнд алдаршсан тул Замбуу тивийн хүмүүний түрүү тэнгэрээс тасарсан мөн ч сүүлд лус, ягчас, асар тэргүүтнээс тасран гарсан их олонтаа хэдүйч Боданчир, Бодан нэрт эмийг авсанаас аймаг түүний ноёныг зохиож, тэр асар нигүүслэн тэтгэж, баатарын ид бах хүч дорвижлого тэргүүтэн эд баялаг ч асар дэлгэрсэн болой. Түүний үндэс дараалалд Хавичи баатар, Бэхир баатар, Махатохан, Хази хүлэг, Бишин хордагшин, Хомбанай цэцэн, Хабул хаан ба Бартан баатар, түүний хөвгүүний их (ууган хүү) Эсүхэй баатар нигүүд гарсан. Урьд Монгол их зонхи хятадын хаадын эрхшээлд буй ч харин заримдаа төвд, тангад хан гүрэний хаан зохиож байжээ. Тэр цагт Эсүхэй баатарт хатан Хөлэн буюу (Ү-гилэн) ба Танагши хэмээхүй 2 буй. Их авгайд (эмд) хөвгүүн 4, охин нэг, бага хатан (эмд) хөвгүүн 2 буй. Их хөвгүүн Тэмүжин нэрт Чагдарын хувилгаанд алдаршсан энэ ямагт 3 дахь Равжун, усан морин жилд мэндлээд шороон нохой жилд Онхирад Дэйни цэцэнгийн охинг, (эм нохой жилтэй) Бөртө зүшэн нэртийг эхнэр болгон авчээ. Шороон хулганад орон хэтэрхий ялгаварт Хэрлүн мөрний сав газарт оршихуй аймаг эний хаанг эрхшээлдээ оруулсан өдрөөс 3 өдөр хүртэл болжмор урьд үзээгүй хоолойдоо (үстэй) өөдтэй далавч өнгө солонгорсон мэт дэлгэрэх бөгөөд дуу яруу нэгэн, урган гарсан, хагархай чулуу нэгний дээр бууснаас Чингис хэмээн 3 таа дуурисан тул өлзий хутагтын билгэ тэмдэгт ухраад хааны алдрыг Чингис хаан хэмээн нэрийдэж, шүтэн барилдлага сайн жигд дэлгэрчээ. Монгол орны номын хаан бодиттойн

тэргүүн болсноор чадагч тэр ямагтын (бурхан багш) үед зүг хотолд амгалан жаргалан чухамтай төгс баяслант хурим мэт болсон буюу. Түүний хөвгүүн сэлтэст Хятад, Төвд, Монгол 3 Үрдүсү Хотан тэргүүтэн Замбуу тивийн тэн талыг эрхшээлд оруулсан энэ адил хятад, монгол, төвдийн хаан бусдад эс гарсан тул энэ нь орон аймаг зарим нэгэнд албат эхнэр, хохигдос ядуу 5 түм, 6 мянга тэргүүтэнг ноён өчүүхэн нижгээдийг хүчээр номын хүрд эргүүлсэн хаан хэмээн алдар нь дуурьсаж тэр мэт бус утга төгөлдөр газрын эсрэгийн (тэнгэрийн) хүчин чадлаар номын хүрдийг эргүүлсэн тэнгэр заяат их хаан мөн магад болой. Энэ мэтээр эрхэндээ хурааж орон аймгийг 29 насны төмөр нохой жилд Зүрчид (манж) хүмүүний эрхэт ванг сэжигдэн албат сэлтийг төлөөсөнд авсан буюу гучин нэгэн насны дээр Солонгосын Ча-хан хаанг эрхэндээ хураах бөгөөс түүний охин Хулан гаог хатанд авснаас суухын цагт нэгэн удаа гэнэт огторгуйгаас их эрдэнийн саванд рашаан дүүрэнг мутарт соёрхосноос энэ нь дээд зүгийн тэнгэрийн хаан нэгэн хайрласаных ба хойжуу монголын хаанд хаш тамга гаргаж лусын хаан өгсөн хэмээхүй.

Тэр 32 насны дээр Татарын Их Цоро нэртийн охин Зисү буюу Зисүхэ эгч дүү хоёрыг хатан болгон авсан. Чингис 33 нас сүүдрийн дээр модон бар жилд хятадын Алтан (хаан)-ыг дайлаад хятадын хааныг зохиож, өмнө зүгт хүрсэнээс хятадын номын ёсыг сайтар нэгэн татсан болой. Тэрээр 34 насны дээр Тодгар (Тухаар) буюу Орос (шар өнгөт) хүмүүний хаан (Сүлди) хэмээхүйг алсанаас түүний хүмүүн аймаг бүгдийг эрхшээлдээ оруулаад, 35 насны дээр Тогмогын (Сартуул) хаан Мунгулигсүлдийг дээрэмдэн түүний албат даярыг эрхэндээ оруулж 37 насны дээр Хэрэйдийн Югийн хаан төрийг буулсан буюу 39 насны дээр Найманы Бадагины хаан Даяныг газрын мухарт хөөж, түүний түшмэл албат бүхэнг эрхэндээ урвуулсан ба 41 сүүдэр дээр Харлогын хаан Нарингийн төрийг булаасан хийгээд 43 насны дээр Харилигын Арслан хэмээхүй цэрэг өмөг их лүгэ төгөлдөр заналтын нэгэн ёс харшилснаас Чингис хаан тэр өөрөө цэрэг сэлтэст хүрсэнээс тэр даруй өөд болохын шалтгаан буюу замд илгээснээс Харилэг бүгдийг эрхшээлдээ урвуулан, 45 насны дээр Төвдийн Үй-д хүрэхийн цагт аймгийн төр баригч Жогоа, Цалба Гунгаадорж тэргүүтэн угтах луга баясгалант хурам агуу ихийг үйлдэх бөгөөс Ай, Ри, Гор 3, Үй Зан, Рү 4, өмнөх Хам, Ган 3 хамаг бүгдийг өргөжүү. Түүнээс Зангын Сажа лам Гунгаа Нямбууд өргөх бичиг, бэлэг сэлтэст хүмүүн элдэв зүйлд муу өвчинг арилган хаа, хаан төр барихуйн ухаан үйл цэргийн зарим нэгэн үл буух тул тэр эцэст хүрэхүйн цагт таны хөвгүүн сэлтэст монголын оронд ялгуусны шашинг арвидуулах хэрэгтэй хэмээн зарлигласанд тэр ямагт бодит учрал ч хэтээс сүслэн багшид барьсан болой. Төвдийн хүмүүн бүхэнг татвараас гаргах бөгөөд Үй зангын 3 шүтэн, хуварагыг эргэн хүндэлж, шашны өглөгийн эзэн номын хаан болжүү. Чингис 46 насны дээр Сартагаочины хаан Амбагауйг алаад, булаах бөгөөс түүний албат бүхэнг эрхшээлдээ оруулсан. Сүүлд 66-ны гал гахай бар сарын адагт тэр хаан анх төвд, тангадад цэрэг илгээсэн бөгөөс түүний (газрыг тэтгэхүй) 9 дэх (хаан) Доржбалма (този) шудрага (Чингис усан махбодитой энэ жил гал махбоди мөн тул чадахуй бэрх гарсан) шудрага (шидүргу) хэмээх сүнсийг татсанаас хүмүүн аймаг хотлоор эрхэндээ хураасан бөгөөс баясгалант хуримыг сар хүртэл үйлдэхүй монголын ламын анханд (хойжууд төвд) алдаршсан хэмээхүй. Тэр цагт түүний хот Дүрвигийн У-лан балгасад хазгай, доош суусан газрыг үл мэдсэнээс То Зигын (Доржбал шудрага) эхнэр Гүргүлжингао түүнийг хорлохын шалтгаанаар Чингис тэнгэр халив хэмээхгүй болой.

Хятадын бичиг зохиол их заримд Чингис (Чинсү хаан) -ийн цэрэг тэр үед Хабутасар архи хүртэх лүгэ амнаас хэтэрч одохуйд хүмүүн аймаг цөөн нэгэнг хүртээж тусгаарт тушааснаас түүний охин үл баясах тул муу үг өгүүлсэн мөн. Мунхагийг үйлдэхүй хөгшин эмд сум тавих хүртэл үзлийг үйлдэн тусгаад Хотонгийн хаанг алж, хатны эгч Чайвубүр хэмээхүйг түүнд эхнэр гэрийг Саргоулын бодит нь 55-ын дээр Тангадыг авсаны сүүлээр Тозигийн Ү-нигэн (Хичи мун) хатанг алж эс чадсан бөгөөд Хар ус мөрнийг хатан гол гэж алдаршсан. Сүүлд хаан Чингисийн Янхар нуурын эрэгт таалал барьсан гэдэг үнэн болой. Шараголын Югэр хүртэлх газрын хувийг Цагаан балгас хэмээхүй. Түүнээс 66 сүүдэр хүртэх хүртэл ямагт хан гүрэн, тойд ноён, албат сэлтэст тэнгэр цэнгүний баясгалант хуримд тэнцэлдэх' үгүй цагт халин зохиожуу.

Чингис гал гахай жил 7-ийн сарын хуучдын 3-ны сайн өдрийн өдөр дунд хаш харцагт шарилыг залсан бөгөөс дагшин оронд заларчүү. Үүнийг номлоход «Хөх дэвтэр» тэргүүтэнд Чингисийг усан бар жилд мэндэлсэн бөгөөд 38 насны дээр хаан ширээнд суусан, гал гахай жилд Тангадыг дараад усан бар жилд Тангад Гхаруд өөд болсон хэмээхүй нь Хятад, Монгол бичиг зохиол шинэ хуучин луга эс зохилдох болой. Түүнчлэнхэд эх, адаг хаан, хаан хөвгүүн тэргүүтний нэрийн дараалал жил завсарт монгол, төвд бичигт ер элдэв зүйлээр өгүүлэхүйч байдаг. Энд Сажа ба монголын хуучин угын бичиг зохиолыг шүүдэглэсэн мэтийг байгуулснаар өчүүхэн нижгээд алдаа байвч удаахад санаа түвдэхгүй болмуй. Чингисийн 5 дахь дүү нь Хабатусар, Бух билгидий, Ойтү, Очидао, Харэтү хачиао, Бүги бандар болой, Тэнгэрийн эрхэг баялаг тэр ямагтад 7 хөвгүүн, охин 2 аваас 9 буй. Хөвгүүн 7 нь хатан дээд Бүлт-гилжингийн хөвгүүн Цагаадай, Зочи, Охидай, Тулай бөгөөс 4 буюу хоёрдахь хатан Хулангийн хөвгүүн Холүгэн, 3 дахь хатан Исүгийн хөвгүүн Чүнмайн Исүдэйн Тази, Зорчидай болой. Эцэг Зүчи Тогмогийн (Сартуул) хаанд тушаагдав. (Хүлэг, Барга, Мимүхүла, Зава, Харахи-рүги, Бүргүл, Шихү-Чүтүг, Зэлми, Чүва мэргэн). Цагаадайд Чинвангийн бошгоос зарлигаар хайрласан бөгөөс Хотон, Тодгарын орны хүмүүнг эрхэндээ авч Ирхэн хотод сууж, энд хөвгүүн 5-аас их нь Абхолхо тэр өөрийгөө түшин барихад агуулаад сүүлд орон эний хаан болов. Хоёрт, Иамахул хотон Кашмирын хаанд заяагдсан тул Самарганы их хотод суув. Гуравт Адирамахамада энэтхэг зүгийн хаанд заяагдаж Балаши их балгасанд суужээ. Дөрөвт, Гонхор Ромын орны хаанд тушаагдаж, Самобхал (Шамбохал) хотод суужуу. Тав дахь Тэмүр нь Урунхайн хаанд заяагдаж, Бхухари хотод суусан бөгөөд тэр тус, тусын орон аймаг хийгээд түүнийг эрхшээлд оруулсан. Чингис хаан (Гизи) Тулийг суурь сахиулд агуулсан нь эцгийн оршихуй үед өөд болов. Хөвгүүн Охидай гал хонин жил тэр өөрийн хааны өр төлөөсөд хятад монголын хаанаар эрхийг дурдах бөгөөс түшмэдийн эрхэм голд Хидан язгуурын Чүца нэрт (Үрлүг) Зүрчидийн мэргэнийг тушаах тэргүүтэнг зохиож хамаг бүхэн тэр өөрийн орших үед бүтээлийг зохиоход шүтсэнээс хүвгүүн тэрээр Равжун 4-ийн шороон хулгана жилээс 6 жил хаан төр барин тэтгэжээ. Тэрний сүүлд түүний хөвгүүн Гү юг, Годан 2-оос урдах модон үхэр жилтэй, усан бичин жилд 6 сар хаан суув. Түүний сүүлээр Годан гал бар жилтэй модон морин жилд хаан ширээнд суусны дараа жилд лусын өвчнөөр шингэхийн цагт Сажа бандидаг урин залж уулзсан бөгөөс лам, «арслангийн дууны үүдэн»-ээс хааны өвчинг арилгасны дараагийн төмөр гахай жилд лам хаан хоёулан таалал барьжээ. Ах дүү энэ 2 умарт зүгийн шар талыг багтаан орны хаан төдийхэнг зохиосноос Үй-г-ийн-их хаа

ныг эс үйлдэв хэмээхүйг эдүгэ энэ мэтийг их хаанд тоолов. Тэр сүүлээр Чингис суурь сахиул Тулайн 4 хөвгүүн их Мүнх гал туулай жилтэй усан хулгана жил хаан ширээнд сууснаас шороон хонин жилд өөд болов. Тэр сүүлд түүний дүү модон гахай жилтэй газрын эрхэт баялаг их, Хубилай цэцэн төмөр бичин жилд хаан ширээнд сууж, тэр модон бар жилд Зан (Төвдийн төв хэсэг) орныг цэргээр аваад, төмөр хонин жил хүртэл хятад, төвд, монгол 3-ыг тэргүүлэн эрхшээлдээ оруулаад Бээжин (Цэцэний эцэг, эхийн шарил, цагаан сувраганы дотор буй) Чахан, Хүра, Түлантад нэрт 4 их хотыг барьсан бөгөөд Сажа Пагвалодой жалцанг тахилд болгосноос 5 дахь Равжун гал бичин жил хүртэл шашны цагаан шүхрийг орчлонгийн үзүүр хүртэлд зорчсон бөгөөд хаан төрийн Хурын энэлгээр анхаарал тавин замбуу тив хамаг их зонхийг хүлцэнгүйдүүлэн зохиосны яруу алдар нь зуны лянхуа буман тоот газрын дээр түгээн зохиож, хязгаараас түшмэл албатын эд барихуд асрал нигүүслэхүй үйлийг баясах тэргүүтний хурын шимийг Ганга мөрний урсгал адил сэлтэст туслан эний баясгаланг хуримын сайн үр агуу ихийг боловсруулсан болой. Чингис хаанаас энэ ямагт хүртэл удаа дараалан эзэлсэн хүмүүн аймаг бол Хөх Монголын хүмүүн айл (гэргийтэн) 4 бум илүү хийгээд улаан хятад, хар төвд, шар Сартагул, цагаан солонгос бөгөөс өөрийн аймаг язгуур өнгө 5 луга багтах бөгөөс охидын орон Зүүнтээ, дунд, гуйлагчийн нүдэт, нохой толгойт бусад аймаг язгуур 4 буюу. Бас дүр ба үйл явдал ухаарах тэргүүтэн ашдаас адил бус хүмүүний язгуур 70 үлэмж (72) буй хэмээхүй. (Хятад бичиг зохиолоос, газрын хувь мөн баруун хойд Торгодын чанх ард буй Хинчаб янагш Монгол хэлээр хэм хэмжээ хэмээхүй зун өдөр урт, шөнө асар богинод нэрлэснээс зүүн хийгээд өмнөдийн тив бага) арал Гойли (Гоули) Манж хийгээд далайн арал Шивин, Хфүван, Сиянло, Сиян тэргүүтэн лүгэ баруунтаа энэтхэгийн (хуваагаад) хагас Кашмирын хязгаараас янагшихад болой. Тэрээс Цэцэн хааны хөвгүүн Дорж ба Мангала, Чин гүм, Номунхон 4-өөс 3 дахь Чингэм хаан ширээнд суух хүртэл урьдын эцэгбэр зарлиг буулгасан хэдүйч нас урт бус ахул түүний хүү Гамал дхарма-бал Үлзиту Туво тэмүр гурваас отгон нь модон үхэр жилтэй модон морин жилээс гал хонин жил (30) хүртэл хаан төр барин тэтгэжүү. Түүний сүүлд Дхармагын хөвгүүн Хүлэг, Буянту 2-ын түрүүч Төмөр могой жилтэй (өнгөрч) мичин жилээс төмөр гахай хүртэл буюу. Түүний сүүлд Буянт модон тахиа жилтэй усан хулганаас төмөр бичин хүртэл буюу. Түүний сүүлд эний хөвгүүн Гэгин (Гэгээн) ба Зияту 2-ын түрүүч нь усан туулай жилтэй (туулай) төмөр тахиа жилээс усан гахай хүртэл хаан ширээнд суухын үед шар хувцаст тэргүүтэн хятадын хувцсыг үйлджүү. Тэрээс Гамалын хөвгүүн Инсүнтэмүр усан могой жилтэй модон хулганаас равжүн 6 дахийн шороон луу хүртэл буюу. Түүний сүүлд Хүлүгийн ууган хүү Рэнчинпаг төмөр хулгана жилтэй ба дүү Голү усан бар жилтэй хоёул шороон могой жилд удаа дараалан хаан ширээнд суусан ч удаагүй. Түүний сүүлд Буянтын бага хөвгүүн Зияату тэмүр модон могой жилтэй түүний сүүлээс усан бичин хүртэл буюу. Тэрээс Минзүн ба Гоосалигын хөвгүүн Рэнчинбал гал бар жилтэй усан бичин тэр нэг сард хаан ширээнд суужээ. Тэрний сүүлд Зияатын хөвгүүн Тогоонтэмүр (Дайтун хотод суусан) О-хату шороон морин жилтэй, усан хулгана жилээс эхлэн хаан ширээнд суусан хэдүйч равжүн 6 дахийн шороон бичин жилийн 8-р сарын 28-нд Хятадын Зүги буюу Дайминд Хятадын талын хаан төрөө булагдсанаас (Шандү) Хэрэлүн мөрний (Хэрлэн мөрний) сав газар одсоноос Бара хот хэмээхүйг барьсан бөгөөс тэнд монгол төдийхний хаан зохиож суугаад тэр төмөр нохой жил өөд болжүү.

Дээд Чингис хаан, хятадын хаадыг эрхэндээ оруулсан жил модон бараас түүнийг хүртэл 8 хаан 75 жил оджүү. Түүний сүүлд монгол оронд удаа дараалан Тогуаны (Тогон) Хөвгүүн Билэгтү (шороон гахай жилтэй), төмөр гахай жилээс буюу түүний дүү Ойхил усан морин жилтэй шороон хонин жилээс буюу түүний 3 хөвгүүний ууган Энхзоригт (шороон гахайтай) Равжун 7 дахийн шороон могойгоос, дундах (төмөр үхэр) Илбэг мигүлхү усан хулганаас орны хаан сууж бөгөөс шороон туулайд өөрийн ач Харгуацагдүрэн хан (шизэг) нэгэнт алан тэр түүний хатан Өлзий хуангү нэрт өчүүхэн охинг авсан хэдүйч тэр жилд Ойрад Үхиги ханха хэмээхүй тэрийг нас барсаны сүүлд хаан Илбэгийг ах хөвгүүн (гал могой) жилтэй Гүнтэмүр төмөр луу жилээс буюу бага Өлзий Тэмүр (шороон хоньтой) усан хонин жилээс, түүний хөвгүүн (модон гахайтай) Дэлбиг (модон гахай) -тай, төмөр туулайгаас Ойрад Хацахайн хүү Исүнхү (гал туулайтай) модон хонин жилээс хаан суусан буюу. Харгуачагийн хөвгүүн (төмөр луутай) Ажи гал морин жилээс төр тэтгэсэн ч шороон морин жилд Ойрад тогуан тизи (Татис) хаан эрийг алахын цагт Тогуан (Тогоон) ч тэр жил үхжээ. Тэрний сүүлд Тогуаны хүү Исин (гал гахай) -тай, шороон морин жил гагцхүүд тэр хаан ширээнд суужээ. Тэрээс Азийн 3 хөвтүүний ууган (усан бартай) Тайсүн шороон хониноос төр тэтгэснээс равжун 8 дахийн усан бичин жилд Ойрад Исин луга тэмцэлдэж хоёулан үхэхийн замд оржээ. Тэрний сүүлд Тайсүний хүү (гал бартай) Минхигү хийгээд эм (гал могой жилтэй) хоёроос түрүүч нь усан бичин жилд хаан ширээнд сууж усан тахиа жилд Түмэдийн Догаолон (Даглон) тайжийг алав. Түүний сүүлд Молон тайж усан тахиагаас буюу Азийн хөвгүүн Мандугуан (гал морьтой) усан хонин жилээс буюу Харгачагийн хөвгүүн Баянмөнх болохжонон (гал бичин чилтэй) шороон тахиа жилээс буюу түүний хөвгүүн модон бичин жилтэй Батумунхи даян, төмөр бар жилээс равжун 9 дахийн усан туулай хүртэл 74 жил хаан ширээнд суужээ. Түүнд хөвгүүн 11 буйн дотроос ууган хүү Төрболод, Улусболод 2 эцгийн сэрүүн ахуй цагт өөд болсон ажээ.

Даян хааны сүүлд Төрболодын хөвгүүн Боди (модон хулганатай) модон луу жилээс буюу түүний 3 хөвгүүний ууган Дарайсан хүдэн (төмөр луутай) шороон бичин жилээс буюу түүний 4 хөвгүүнээс Зүгтү, сүүл нь Бахай, Дайчин (шороон гахайтай) ууган Түмэн шороон морин жилээс буюу 11 хөвгүүний ууган Буян цэцэн (модон туулайтай) Равжун 10 дахийн усан луу жилээс буюу энэ 3 хөвгүүнээс (Мангур, Равгар, Морүхэтан) ууган Мангур Тайжийн 2 хөвгүүний (Сасарзи) ууган Лигдэн баатар (усан луу жилтэй, модон луу жилээс 31 хүртэл хаан ширээнд суусан хэдүй ч модон нохой жилээс Монгол орны хаан төрийг барьсан хэдүйч алдсан бөгөөд үхэхийн замд оджүү. Тэр мэт тэнгэр заяат хаан Чингэсээс эхлээд Тогуан Тэмүр хүртэл их хаан 16, хамаг бүхэн дээд цэцнээс янагшихад 11 хаан Хятадын төв, хязгаарын хаанг зохиосон тул Хятадын хааны уг дамжлагат үзэхүйг уридаа өгүүлэн барьсан мэт. Тэрээс Хятадын цагаан хэрмийн гаднах монгол төдийхэнд хаан зохихуй бага хаан Лигдэн хутагтыг хүртэл 21-ийг хураахад Боржигон язгууртын хаан 35, Ойрадын хаан 2 бөгөөс хаан 37-ын үед (хөвгүүдийн үр дамжлага 22) хаан төр барин тэтгэсэн шороон тахиа жилээс модон нохой жил хүртэл 446 жил (модон нохой жил хүртэл) одсон билээ. Хааны сүүл Лигдэн хутагт хааны сэтгэлд этгээд авир оршсон бөгөөд (Шанпрүл ванжид) бусдын ирд эрхийг үйлдэхүй эзний охин Линхуан эрхэсийн оройн 5 сум туссан луга буруу санаат баясгалант машдын хүрдэнг тэмцэлдэн үйлдэгч тэргүүтэн 4-ч ноёд, албатын зүрхэнд оршихуй сэлтэст тэрээр үрүдсү (орүдүсү) - гийн жононгийн хатанг булаах бөгөөд Хөх нуурын зүгийн эзэнг үйлд-

сэнээс Төвдийн Зангийн хаанаар суух бөгөөтөл, буяны ёсны шашин номыг дарахыг хүссэнээс (Дод)-ийн биен зүгт одсон хэдүйч номын хаан, гадаад, дотоод нууц 3-ын чадлаар Хөх нуурын умрын ар талд насан өөд болсоноос 2 хатан, 2 хөвгүүн сэлтэст (Эжихонгор) (Абахай) сөргөө буцах бөгөөс Мүгдэнд хүрээд Зүрчидийн Тайзугийн хөвгүүн Урхачи баатар (Урхачи баатур) буюу хятад хэлээр Тиүзүн нэртийн хүү (Шизү) хаан нэрт тэргүүн зүүжээ.

Улаан Хятадын хаан Алтангийн язгуурт усан бичин жилд мэндэлсэн Найрамтхи богд цэцэн буюу Шизу Шүндажи хаан модон гахайнаас (Монгол) тэргүүтэнг эрхэнд оруулсан бөгөөд Лигдэн хааны хүү Эрхэхонгор хөвгүүн Монан түшмэлд тушаагдсан Хаан түүний хөвгүүн ивээр засагч (шороон бар жилтэй) модон бичин жилээс хятадын (Лиси) хааны төрийг булааж, Бээжин тийн ордонд сууснаас лам нигуудад Дай, гүүш, Гинша тэргүүтэн цол, засаг тамга хийгээд манж ба монголын хаад ноёд нигуудад гүн, засаг цол зэргэмж өгснөөр эдүгээ ч Монголын хаад хиа, бага хаад, ноён, тайж нигууд, өөр, өөрийн хүмүүн аймгийг эрхшээлд оруулснаас ном хийгээд төрийн цог заль юун алин явдал чилэх болой. Мөн тэдгээр хаан зохиохуй жилийн тоо монголын ном зохиолд заримд болбоосуу зэргэмжид Чингис (Чингис) модон үхэр жилээс 35 жил, Өгөдэй 3 жил, Мөнх 6 жил, Цэцэн хаан 35 жил, Өлзийт 14. Хүлэг 5, Буянт 4, Гэгээн хаан 3, Исүн тэмүр 6, Рэнчинпаг 5, Госула хутагт нэг сар, Заяту 4 жил, Эрдэнэцогт Ухату 1 сар, Тогуантэмүр 6 жил оршсон болой. Мөн заримд Чингис модон үхэр жилээс гал гахай хүртэл 23 жил, Өгөдэй 6 жил, Гүюг 6 сар, Мүнхи 9 жил, Цэцэн хаан 46 жил, Өлзийт 13 жил. Хүлүг 4 жил, Буянт 9 жил, Гэгээн 3 жил, Исүнтэмүр 5 жил, Рэнчинпаг 5 жил, Госали нэг сар Заяту (Гармаа Ранжүнг урин залсан) 3 жил, Данашри нэг сар (Хятадын Манзигээс заларсан) Тагуантөмөр усан хулганаас шороон бичин жил хүртэл 36 жил бөгөөс модон үхэр жилээс аваад 164 жил хэмээхүй ажээ. Мөн хятадын бичиг зохиолд зарим Чингис модон үхэр (гал бар) жилээс (Тайзу ин вэн хуанди) Өгөдэй нэг жил (хори) завсарлага зохиож, тэр төр тэтгэхүйн ёсыг суралцсанаас шороон үхэр жилээс 13 жил суусан бөгөөд Сажа бандидаг урин залсан ба түүний хөвгүүн Гүюг 6 сар (Зүнгү ёнзин) Тулэйн хүү морин жилтэй 18 (Хи янзүн хүнсү) түүний ач Цэцэн (Шизү шинди шингүн вэн сү) 35 жил, түүний ач Тувотэмүр (Чинзүн сүнхи оу) буюу Өлзийт үл урвахуй, Чинбат тамгыг шинээр олоод тэр 13 жил ба түүний дүүгийн хүү Хайсан хүлүг 4 жил, (Зүн танхир) түүний дүү Юүр бадвада буюу Буянту (Шинзүн хин хиү) 9 жил түүний хүү Шүд (Инзүн шиша) буюу Гэгээн (Гигэн) 3 жил сууснаас малгай, хувцас тэргүүтэнг хятад мэт урвуулсны сүүлд Чингис ач Исүнтэмүр (Дайдин) 5 жил, түүний их хүү (Рачипаг) Асугава 3 сар суусны сүүлд V зэн хүлүгийн хүү Түг тэмүр булаасан бөгөөд дүү Тушалид тушаагдсанаас тэр 8 сар хийгээд тэрний сүүлд Зия тү түг тэмэр (Вэнзүн) тэр өөрөө 3 жил Минзүн гушалигын хүү Рэнчинбал нэг сар, түүний дүү Тогуан Тэмүр буюу Ахаулгуй шороон бичин хүртэл 36 хаан, хаан ширээг түшсэн бөгөөд бүгд 164 жил өнгөрсөнд Хятадын орон хязгаар, төв бүхэнг Цэцэн хаан шороон туулайгаас эрхшээлдээ урвуулснаас шороон бичин жил хүртэл 84 жил өнгөрөв хэмээхүй. (Хуайзүн шүн хуйхи) Тогуан тэмүрээс янаг шихад олонтой урьд сүслэхүй мэт буюу. Мөн зарим нэгэн монгол орон төдий (266)-д Тогуан бодиттой 3 дахь Билэгтүү хаан 8 жил, Ойхал 21 жил, Зоригту 4, Энхи 4, Илбэгнигүн лайхад 9 жил, Гүн тэмүр 4 жил, Улизиту тэмүр 3 жил Дэлбэг 5 жил, Ойнода (Хойчид Тэмүчигуан) 11 жил Ажай 14 жил, Тэйсүн 15 жил, Мэрхэйд 2 жил, Молом 4 жил, Мандулүг чонхар Гуачай 5, Баянмөнхү жонон 4 жил,

Батмөнхү даян хаан 48 жил суусан бөгөөд баруун 3 ястан, (цахар, халх) (Үр-син ан гуан) Зүүн 3 ястан бөгөөс 6 ястан хийгээд Хишигтэн (Өмнөх хошуу)-ийн (Онхон, Найман, Тэдэр, Алаг чигуан үзэмчин) арын 4, бөгөөс 8 хошуу хийгээд цэрэг 13 түмтийг эрхшээлдээ урвуулсан хэмээхүй, заримаас эрхэчиүдийн 2 тайж цэрэг луга сэлтэст Тайсүн хааны аймаг олноор алах цагт Тайсан хүүг Хартучагтис хэмээхүй өчүүхэн охин луга хагацах бөгөөс Монгол орны хотон оронд зугатсанаас тэнд суухын цагт охин бие давхар болохын янар тэнд буйд хүн нэгэн гарсан дайсанг алахаас сэжигдэж, 2 тайж Маса мүрэгүнзи нэрт гэрээр монгол оронд дөхүүлэн сүүлд тэрний нэр Болоху жонон хэмээхүй тэр мөн хэмээхүй хийгээд зарим нэгэн тэр Даян хаахаанг мөн хэмээхүй үзэгдэхүйч Даян хаан бол Чингисийн уг дамжлага мөн нь магадтай хэмээгдэхүй. Хаан тэрээс Сайнмандухай хийгээд Самүр Тайху ба Бүсай хэмээхүй хатан 3 буйн Их хатны хөвгүүн Төрболод, Улусболод 2, Вачирболод, Алчуболод 2 (хөвгүүн Анзу Шараг 2) Алсугуар, Гангүн 12 бөгөөс 8 лүгэ датувур (татвар) эмд Гри болод, Гэрсэнз 2 луга өчүүхэн эмд Чинтайж Зигарүди (хүү үгүй) 2 нэлээд хөвгүүн 12 буй. Заримаас Хүсайгын дагуул эм ба Зимэгэнээс янагшихад бус бөгөөд хөвгүүн 11 хэмээхүй. Тэр хийгээд Түрболд нэг жил, түүний 2 хөвгүүнээс Бодиалаг хаан 13 жил, Түмэн засагт хаан 3 жил, Буянт цэцэн хаан 49 жил, Мандуй тайж 7 жил. (Лигдэн) Линдан хутагт 30 жил хаан ширээг зохиов хэмээжүү.

¹ Ишбалжир «Галбарвасан модун» IV бүлэг, 2 дахь тал

Д. Цэдэвийн монгол орчуулга (ДДСХ-ийн фонд)

² Эрдэнэтэй, Оюундалай (БНХАУ) «Монголын нууц товчоо» 190 дахь тал, 1980.

Хөх хот. (хятад хэлээр)

³ Дорнотив (БНХАУ) «Монголын нууц товчоо» 19 дэх тал, 1979, Хөх хот. . (хятад хэлээр)

⁴ Проф. Озово (Япон) «Монголын нууц товчоо» 3 дахь тал. 1984, Токио

⁵ Ц.Дамдинсүрэн «Монголын нууц товчоо»

⁶ Мөн тэнд

⁷ Дорнотив «Монголын нууц товчоо» I дахь тал, 1979, Хөх хот

МОНГОЛ, ВЬЕТНАМЫН ЭЛЧИН ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭЭС

С. Дашцэвэл

Монгол, Вьетнам хоёр улсын элчин харилцаа эртний уламжлалтай. «Их Вьет гүрний түүхийн бүрэн тэмдэглэл» хэмээх вьетнамын эртний нэгэн сурвалж бичигт «1168 оны шар хулгана жил татарын элч нийслэл Тханг Лонгд хүрэлцэн ирэв. Мөн үеэр Өмнөд Сүн улсын элч ирсэн тул 2 элчийг хооронд нь уулзуулсангүй»¹ хэмээжээ. Үүнээс үзвэл монгол, вьетнам хоёр улс лавтайяа 700 гаруй жилийн тэртээгээс бие биенээ мэддэг байжээ. Монголчуудыг тэр үед харь улс гүрнүүд «татар» хэмээн нэрлэж байсан бөгөөд вьетнамчууд ч гэсэн тийн нэрлэж